



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 12

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын тамгын газарт нийт 19,901,361.63 төгрөгийн балансын үнэтэй 10,945,748.89 төгрөгийн хурумтлагдсан элэгдэл бүхий дизель түлш үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг балансын үнээр нь бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Эрдэнэсүрэн дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

Дөрөв: Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2017 оны 10 сарын 18 ны өдрийн 60 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

С.СҮХБААТАР

480219110